

Вьетнам-Хятадын газар нутгийн маргаан

Б.Цэнгэлхам¹

South China Sea dispute is a typical example of a regional conflict around the world and it is located in one of the most geopolitically and economically important parts of the region. 80 percent of oil imports from China, Japan, South Korea and the Middle East passes through the South China Sea. Most of the exported and imported goods from the South Asia, Africa and Europe are transported and shipped through this disputed sea. If the dispute leads to even more serious conflict, it would definitely impose a negative impact on the global economy.

The paper defines all of the disputed areas in the South China Sea and discusses about its historical reasons in chronological frame followed by an analysis on the current situation. Bilateral policies and political views of the two governments on the South China Sea issues are discussed critically with further analysis on the potential impact of the conflict on the bilateral diplomatic relations.

Currently there exists many interests of the two governments that conflict with each other. However it is not possible to have an intention to politically dominate in the region. The most effective measure to solve the conflict would be a bilateral discussion which would define a future of the bilateral relations between the two nations.

* * *

Өмнөд Хятадын тэнгисийн маргаан нь дэлхий дахинд болж буй бүс нутгийн зөрчилдөөний нийтлэг жишээ бөгөөд олон улсын эдийн засгийн хувьд стратегийн ач холбогдол бүхий байршилд бий болжээ. Хятад, Япон, Өмнөд Солонгосын Ойрхи Дорнодоос импортлодог газрын тосны 80% нь энэ тэнгисээр дамжин өнгөрдөг. Өмнөд Ази,

1. ШУА-ийн Олон Улсын Харилцааны Хүрээлэнгийн ЭША, ts_lham@yahoo.com

Африк, Европоос экспортолж, импортолдог бараа бүтээгдэхүүний ихэнх нь Өмнөд Хятадын тэнгисээр тээвэрлэгддэг. Энд дайн үүсвэл дэлхийн эдийн засагт сөргөөр нөлөөлнө.

Өмнөд Хятадын тэнгис нь Зүүн өмнөд Ази болон Өмнөд Хятадын дунд оршдог, ойролцоогоор 3,5 сая хавтгай дөрвөлжин км талбайг хамарсан хагас битүү далай ба Хятад, Вьетнам, Филиппин, Индонез, Бруней, Малайз, Сингапур, Тайланд, Камбож улстай хил залгадаг.

Өмнөд Хятадын тэнгис дэх нутаг дэвсгэрийн маргаан нь Хятад, Вьетнам, Филиппин, Индонез, Бруней, Малайз гэсэн улсуудыг хамардаг.


- Вьетнамын далайн эргийн далайн хил: Вьетнам, Хятад, Тайваний хооронд,
- Хойд Нагуна арлуудын далайн хил: Индонези, Хятад, Тайваний хооронд,
- Хойд Борнеогийн далайн хил: Вьетнам, Хятад, Тайвань, Малайз, Филиппин, Брунейн хооронд,
- Спратлийн бүлэг арлууд: Вьетнам, Малайз, Филиппин, Бруней, Тайвань, Хятадын хооронд,
- Төв Филиппиний далайн эргийн далайн хил: Филиппин, Хятад, Тайвань хооронд,
- Параселийн бүлэг арлууд: Вьетнам, Хятад, Тайваний хооронд,

Хэдийгээр энэхүү арлууд тус бүс нутаг дахь олон улс орны маргаан мэт боловч гол маргаан Вьетнам, Хятад, Филиппин улсуудын хооронд явагддаг.

Ази, Номхон далайн бүс нутгийн хурцадмал асуудлын нэг болох Өмнөд Хятадын тэнгис дэх газар нутгийн маргааны учир шалтгааныг судлах, түүнийг хэрхэн шийдвэрлэх нь дэлхийн бусад зөрчил, мөргөлдөөнийг зохицуулах арга замыг олох, маргааныг шийдвэрлэхэд туршлага болно.

Маргаантай газрын нэрс

Олон улсын нэршил	Вьетнам нэршил	Хятад нэршил
South China Sea (Өмнөд Хятадын тэнгис)	Bien Dong (Зүүн тэнгис)	Nanhai (Өмнөд тэнгис)
Paracel Islands (Параселын бүлэг арлууд)	Hoang Sa (Алтан элсний бүлэг арлууд)	Xisha (Баруун элсний бүлэг арлууд)
Spratly Islands (Спратлийн бүлэг арлууд)	Truong Sa (Урт элсний бүлэг арлууд)	Nansha (Өмнөд элсний бүлэг арлууд)
Woody Island (Ой модны арал)	Dao Phu Lam (Ой модны арал)	Yongxing dao (Аз жаргалын арал)
Itu Aba island (Итү Аба арал)	Dao Ba Binh (Энх тайваны арал)	Taiping dao (Энх тайваны арал)
Nine-dashed line (Есөн зураас шугам)	Duong luoi bo (Үхрийн хэлэн шугам)	Nanhai Jiudianxian (Өмнөд тэнгисийн есөн зураас шугам)



Маргааны шалтгаан

➤ Стратегийн байршил

Өмнөд Хятадын тэнгис, ялангуяа Парасель, Спратлийн бүлэг арлууд нь Хятадын гадаад ертөнц рүү гарах боомт бүхий стратегийн хувьд чухал бүсэд оршдог. Японы хувьд Өмнөд Хятадын тэнгис нь Зүүн Өмнөд Азид төдийгүй Ойрхи Дорнод, Европт хүрэх гол тээврийн зам байсан. Дэлхийн 2-р дайны үед Япончууд Спратлийн бүлэг арлууд дахь Итү Аба арал дээр шумбагч онгоцны бааз байгуулж байсан.

Энэ бүс дэлхийн хамгийн их ачаалалтай тээврийн замын нэг юм. Жил бүр дэлхийн хөлөг онгоцны ачаа тээврийн тэн хагас нь Малаккийн хоолой, Сундын хоолой болон Ломбок хоолойгоор явж, тэдгээр хөлөг онгоцны ихэнх нь Өмнөд Хятадын тэнгисийг дайран өнгөрдөг. Малаккийн хоолойгоор дамжин Өмнөд Хятадын тэнгис рүү гардаг газрын тос тээвэрлэгчдийн тоо Суэцийн сувгаар дамжин өнгөрөгчдөөс

3 дахин, Панамын сувгаар дамжин өнгөрөгчдөөс 5 дахин олон байдаг байна².

Ачааны ихэнх нь түүхий газрын тос, шингэрүүлсэн байгалийн хий, нүүрс, төмрийн хүдэр давамгайлж байна. Малаккийн хоолойгоор дамжин өнгөрч буй тээврийн талаас илүү, Спратлийн бүлэг арлаар дамжин өнгөрч буй тээврийн хагас нь Персийн булангийн түүхий газрын тос байдаг.

Өрнөдийн судлаачдынхаар Спратлийн бүлэг арлуудыг захирч буй улс Өмнөд Хятадын тэнгисийг бүхэлд нь хянах боломжтой гэж үздэг байна.

➤ Байгалийн баялаг

Газрын тос: Өмнөд Хятадын тэнгис газрын тосоор баялаг. Газрын тосны орд Өмнөд Хятадын тэнгисийн эрэг орчмын ихэнх улс орнуудад олдсон байна. Энэ бүс нутагт ойролцоогоор 7.5 тэрбум баррель газрын тос³ бий гэдгийг баталсан ба бүс нутаг дахь газрын тосны үйлдвэрлэл өдөрт 1,3 сая баррель⁴ байна. Өмнөд Хятадын тэнгисийн нийт үйлдвэрлэл сүүлийн хэдэн жилүүдэд аажмаар өсч, Хятад, Малайз, Вьетнамын үйлдвэрлэл нэмэгдэн, гадагш тэлсэн байна.

Хятадын судлаачийн тооцож гаргаснаар Парасель, Спратлийн бүлэг арлуудын газрын тосны нөөц 105 тэрбум баррель⁵, Өмнөд Хятадын тэнгисийн нийт газрын тосны нөөц 213 тэрбум баррель⁶ байх юм.

Байгалийн хий: Өмнөд Хятадын тэнгис байгалийн хийгээр баялаг. Ихэнх орд газрууд Бруней, Индонез, Малайз, Тайланд, Вьетнам, Филиппин улсын Өмнөд Хятадын тэнгисийн бүс нутагт судлагдсан. АНУ болон өөр бусад улсуудын геологийн судалгаагаар бүс нутаг дахь байгалийн хийн хэрэглээ жилд дунджаар 5%-иар өсөх төлөвтэй байна. Хэрэв нэмэлт дэд бүтэц байгуулбал байгалийн хийн хэрэглээ ч илүү хурдан нэмэгдэж болох юм.

2. <http://www.globalsecurity.org/military/world/war/spratly-ship.htm>

3. <http://www.tinmoi.vn/tag/bien-dong>

4. <http://www.tinmoi.vn/tag/bien-dong>

5. <http://www.tinmoi.vn/tag/bien-dong>

6. <http://www.tinmoi.vn/tag/bien-dong>

Өмнөд Хятадын тэнгисийг дамжин өнгөрдөг шингэрүүлсэн байгалийн хийн тээвэрлэлт дэлхийн шингэрүүлсэн байгалийн хийн худалдааны гуравны хоёрыг бүрдүүлж байна. Хамгийн том хүлээн авагч нь Япон. Өмнөд Солонгос (эрчим хүчний хэрэглээ 7%), Тайвань (эрчим хүчний хэрэглээ 4%) нь Өмнөд Хятадын тэнгисээр шингэрүүлсэн байгалийн хий их хэмжээгээр импортолдог.

➤ **Загас агнуур**

Өмнөд Хятадын тэнгис дэлхийн загас агнуурын 8%-ийг эзэлдэг. Өмнөд Хятадын тэнгист Хятад, Вьетнам, Филиппиний загас агнуурын хөлөг онгоцнуудын хооронд олон мөргөлдөөн гарсаар ирсэн. Хятадын загас агнуур болон далайн газрын тосноос олох ашиг 1 их наяд ам.доллар болж өснө гэж үзэж байна.

Маргааны түүх

Хэдийгээр Өмнөд Хятадын тэнгисийн маргаан нь 1974 онд Парасель, 1988 онд Спратлийн бүлэг арлын тулаанаас хойш гарч эхэлсэн гэж үздэг ч үнэндээ саяханаас хурцадмал байдалд ороод байгаа энэхүү маргаан бодит байдал дээр ХХ зууны эхний жилүүдэд анх гарсан байдаг.

Маргааныг түүхийн үүднээс 5 үед хуваан үздэг. Үүнд:

- I үе буюу 1909-1930 он
- II үе буюу 1930-1945 он
- III үе буюу 1945-1954 он
- IV үе буюу 1954-1975 он
- V үе буюу 1975 оноос одоо хүртэл

Түүхийн өөр өөр нөхцөл байдлууд маргааны өөр өөр шалтгаануудыг дагуулсаар өнөөдрийг хүрсэн байна.⁷

➤ **I үе буюу 1909-1930 он**

Вьетнам 1858 онд Францад эзлэгдэн, 1884 онд Францтай хийсэн

7. <http://www.diendan.org/phe-binh-nghien-cuu>

эцсийн гэрээгээр бие даасан бүрэн эрхээ алдаж, гаднын улс орнууд түрэмгийлэх үед Параселийн бүлэг арал дахь өөрсдийн тусгаар тогтнолыг батлан хамгаалж чадахгүй байдалд хүрсэн. 1909 оны 6-р сард Хятадын Гуандун мужийн дарга Занг Ренжун анх удаа Вьетнамын эзэмшилд байсан Парасель буюу Хоанг са (Алтан элс) арал руу жижиг флотыг илгээсэн. Улмаар 1907 оны 7-р сараас 10-р сар хүртэлх 3 сарын хооронд Пратаг (Dongsha) дахь Японы түрэмгийллийн үр нөлөөгөөр Хятад Хайнаны ойролцоох Параселийн бүлэг арлыг эзэлж авсан.

➤ II үе буюу 1930-1945 он

Параселийн бүлэг арлууд Вьетнамд харьяалагдаж байсан. Параселийн арлуудын талаарх анхны судалгаа 1925 онд хийгдсэн. Параселийн бүлэг арлуудын Хоанг са дүүрэг гэж нэрлэгдэх засаг захиргааны нэгжийг байгуулахаар SC-156 тогтоолыг 1932 оны 6-р сарын 15-нд Францын Засгийн газар гаргасан.

Спратлийн бүлэг арлууд нь Францын колони байсан Өмнөд Вьетнамд харьяалагдаж байсан. 1933 ны 4-р сарын 13-нд тэнгисийн цэргийн дэд хурандаа Де Латте Сайгоноос Спратлийн бүлэг арлууд руу их бууны хөлөг онгоц, усан цэргийн хөлөг онгоцоос бүрдсэн бага хэмжээний усан флот явуулахыг тушаасан.

1938 онд Францын засгийн газар Аба (Taiping)-д гэрэлт цамхаг, цаг уурын станц барьсан.

➤ III үе буюу 1945-1954 он

Дэлхийн II дайны дараа Францууд Вьетнамыг колончлохоор буцан ирж, Чан Кайшигийн арми Японы цэргүүдэд эзлэгдсэн байсан хойд Вьетнамыг авсан. Франц, Хятадад аль алинд нь Парасель, Спратлийн бүлэг арлуудын төлөөх маргаан үргэлжилсээр байсан.

1949 оны 4-р сард Вьетнамын тал Сайгон хотод болсон хэвлэлийн бага хурал дээр олон нийтэд Параселийн бүлэг арлууд дээр Вьетнам урт хугацааны бүрэн эрхтэй гэдгээ дахин нотолсон.

1954 он гэхэд Франц албан ёсоор Вьетнамын Засгийн газарт арлыг удирдах эрхийг хүлээлгэн өгсөн.

➤ IV үе буюу 1954-1975 он

Энэ үед Вьетнам БНАВУ, БНӨВУ болон хоёр хуваагдсан байсан. 1956 оны 6-р сарын 1-нд БНАВУ Парасель, Спратлийн арлууд дахь Вьетнамын бүрэн эрхийг баталгаажуулж мэдэгдэл хийсэн. 1956 ны 8-р сарын 22-нд Вьетнамын тэнгисийн цэргийн хүчин Спратлийн бүлэг арал дээр БНӨВУ-ын тугийг мандуулсан.

1956 оны 10-р сард БНХАУ Спратлийн бүлэг арлуудын Вуди арлыг эзлэн авсан. АНУ болон БНХАУ-ын хооронд 1972 онд гаргасан Шанхайн хамтарсан мэдэгдэл нь Вьетнамын дайныг эцэс болгосон хэдий ч ЗХУ болон БНХАУ-ын хоорондох харилцаанд гарсан ан цавыг арилгаж чадаагүй.

1973 онд Парисын гэрээ байгуулж бүх улс орнуудад албан бичиг илгээснээр БНАВУ-ын Засгийн газар Вьетнамын нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлын талаар дахин авч хэлэлцэх тусгай хуралдаан хуралдуулж өгөхийг НҮБ-ын аюулгүйн зөвлөлөөс хүссэн байдаг.

➤ V үе буюу 1975 оноос одоо хүртэл

1975 оноос 1990 онд Вьетнам улс ЗХУ-тай иж бүрэн харилцаатай байсан. 1972 оны АНУ ба БНХАУ-ын хамтарсан мэдэгдэл нь Хятад, ЗХУ-ын хоорондох зөрчилдөөнийг ихэсгэсэн. Парасель, Спратлийн бүлэг арлуудын талаар Вьетнам, БНХАУ-ын хоорондох маргаанаас 1979 оны Вьетнам-Хятадын дайн нь үүдэлтэй.

1982 оны 12-р сарын 9-нд Вьетнамын Засгийн газар Жыөнг са (Спратли) дүүргийг байгуулж, уг дүүргийг Фу Кхань мужид харьяалагдана гэсэн шийдвэр гаргасан.

1988 оны 3-р сарын 14-нд Өмнөд Хятадын тэнгист Хятад, Вьетнамын хооронд мөргөлдөөн гарсан. Нийт 28 минут үргэлжилсэн мөргөлдөөнд дэлхий нийтээрээ санаа зовниж байсан.

1988 оны 4-р сарын 6-нд Хятад шүрэн арал гэх мэт хэд хэдэн арлуудыг эзэлсэн.

1988 онд БНСВУ-ын Засгийн газар Бээжин рүү хэд хэдэн эсэргүүцлийн ноот илгээж маргааныг хоёр тал хэлэлцэн тохиролцох

санал тавьсныг НҮБ-д мэдэгдсэн. Хятад улс яриа хэлэлцээр хийхээс татгалзаж байсан.

1988 оны 4-р сарын 14-нд БНСВУ-ын ГХЯ Хайнань мужид Парасель, Спратлийн арлуудыг нэгтгэх БНХАУ-ын БХАТХ-ын тогтоолыг эсэргүүцсэн. (1988 оны 4-р сарын 13-ны тогтоолоор Хайнань муж байгуулагдсан).

2012 оны 7-р сард Вьетнамын Үндэсний ассемблей Парасель, Спратлийн бүлэг арлууд багтсан далайн хилийг заагийг хуульчлан баталсан.

Өнөөгийн байдал

2014 оны 5 сараас Хятад, АСЕАН улс орнуудын хоорондын нутаг дэвсгэрийн маргаан хурцдаж эхэлсэн ба шатахууны хомсдол, хүнсний аюулгүй байдал, стратегийн байршлаас шалтгаалсан байж болох талтай.

2014 оны 5-р сарын 2-7-нд Вьетнамын эргээс 132 милийн зайд Хятадын тал “СНООС 981” газрын тосны өрөмдлөгийн цамхаг босгож түүнийг хамгаалах олон арван усан онгоц илгээсэн. Вьетнамын тал эх газрын эргээс 200 миль хүртэл далай тэнгисийг өөрийн эдийн засгийн онцгой бүс хэмээн үздэг тул тэр бүсэд Хятадын тал дур мэдэн цөмөрч газрын тосны цамхаг босгож байгааг эсэргүүцэн тэнгисийн цэргийн хөлгөөр хориглон зогссоноос уг мөргөлдөөн гарсан.⁸

Вьетнамын эрх баригчид улсынхаа ашиг сонирхлыг хамгаалахын тулд шаардлагатай гэж үзсэн бүх арга хэмжээг авна хэмээн Хятадын талд анхааруулжээ. Вьетнамын албаныхан 1982 оны НҮБ-ын далайн хуулийн конвенциор тогтоосон тус улсын эдийн засгийн онцгой бүсэд Хятад улс газрын тосны өрөмдлөгийн цамхагаа байршуулсан⁹ гэж мэдэгджээ.

Вьетнамын тал эх газрын эргээс 200 миль хүртэл далай тэнгисийг өөрийн эдийн засгийн онцгой бүс хэмээн үздэг тул тэр бүсэд хятадын тал дур мэдэн цөмөрч газрын тосны цамхаг босгож байгааг эсэргүүцэн тэнгисийн цэргийн хөлгөөр хориглон зогссоноос уг мөргөлдөөн гарсан байна.

8. С. Дашцэвэл, Өмнөд Хятадын тэнгист юу болж байна вэ?, 2014

9. <http://www.nguyentandung.org/cat/an-ninh-quoc-phong-bien-dao>

Вьетнам даяар Хятадын эсрэг эсэргүүцлийн хөдөлгөөн хүчтэй өрнөсөн. Вьетнамын хэд хэдэн мужийн аж үйлдвэрийн бүсүүдэд нэлээд хоногийн турш үргэлжилсэн хөдөлгөөн 20 мянга гаруй хүн оролцож, Хятадуудын эзэмшилд байдаг гурван үйлдвэрийг галдан шатааж, хэдэн хэдэн байр руу нь дайрсан байна. Уг жагсаалын улмаас 15 үйлдвэр хохирол амсч, үйл ажиллагаанд нь саатал учирч, 21 хүн амиа алдаж, 150 гаруй хүн гэмтэж бэртжээ. Вьетнамын хөлөг онгоцууд тус цооногийг байрлуулахад саад болох гэж оролдох үед Өмнөд Хятадын тэнгис дэх усан онгоцонд нь халдсан хэмээн вьетнамчууд Хятадыг буруутгасан.

Хэдийгээр маргаантай арлууд байнгын оршин суугчгүй, жижиг ч гэлээ эзэмшиж байгаа улсууд нь цэргийн хүч байрлуулах замаар бүс нутгийн далайн тээврийн гол замуудыг хянах боломжтой ба Ханой “манай эдийн засгийн онцгой бүс” хэмээдэг бол Бээжин “Хятадын нутаг дэвсгэр” гэж үздэг.

Энэхүү газар нутгийн маргааныг эв зүйгээр зохицуулахын тулд бүс нутгийнхан багагүй чармайлт гаргаж Зүүн тэнгисийн тухай 1992 оны АСЕАН-ы орнуудын Тунхаглал, 1997 оны АСЕАН-Хятадын хамтарсан мэдэгдэл, 2005 оны Вьетнам, Хятад, Филиппин гурван улсын газрын тосны ХХК-уудын хайгуул, судалгааны хамтарсан хөтөлбөр гэх мэт хэд хэдэн чухал баримт бичигт гарын үсэг зурсан. Гэвч эдгээр нь голдуу цаасан дээр үлдэж байгаа бөгөөд яг хэрэгжүүлэх шатанд Хятадын талын хойрго хандлага, булгаж булзааруулсан байр суурь саад болсоор байгааг АСЕАН үе үе дурддаг.

Саяханаас АНУ Өмнөд Хятадын тэнгист цэргээ байршуулах талаар мэдээлж байна. Цаашид хэрхэх нь мэдэгдэхгүй байна. Цаг хугацаа байдлыг харуулна.

Вьетнамын бодлого, байр суурь

Вьетнамын бүрэн эрхт байдлаа хангах зорилгоор Өмнөд Хятадын тэнгисийн талаар хэрэгжүүлж байгаа бодлогыг дараахь байдлаар томъёолж болно.

➤ Цэрэг армиа бэхжүүлж, шинэчлэх

Вьетнамын Ардын арми нийт байнгын 482 мянган цэрэгтэй, түүний 412 мянга нь явган цэрэг, 42 мянга нь тэнгисийн цэрэг, 30 мянга нь агаарын хүчин юм.

Хил хамгаалах хүчин, эргийн хамгаалалтын хүч, хагас цэрэгжсэн хүчин, нөөцний хүчин нийт 5 сая орчим гэсэн тооцоо байдаг.¹⁰

БНХАУ-ын цэргийн хүч, батлан хамгаалах салбарт зарцуулж буй төсөвтэй харьцуулахад Вьетнамын ардын армийн төсөв бага. Вьетнамын цэргийн хүчээ шинэчлэх үйл ажиллагаа одоо хийгдэж байгаа ба ялангуяа тэнгисийн цэргийн хүчээ бэхжүүлэхэд илүү анхаарч байна. Вьетнамын цэргийн зардал нэмэгдэж байгаа гэдэг нь үүнийг илэрхий нотолж байна.

Он	2005	2006	2007	2009	2011	2013	2014
ДНБ	45.4 тэрбум ам.доллар	52.4 тэрбум ам.доллар	60.9 тэрбум ам.доллар	90.3 тэрбум ам.доллар	103.6 тэрбум ам.доллар	141.7 тэрбум ам.доллар	187.8 тэрбум ам.доллар
Батлах хамгаалах салбарын төсөв	0.9 тэрбум ам.доллар	1.2 тэрбум ам.доллар	1.6 тэрбум ам.доллар	1.5 тэрбум ам.доллар	2.6 тэрбум ам.доллар	3.4 тэрбум ам.доллар	4.7 тэрбум ам.доллар
ДНБ-д эзлэх хувь	1.9 %	2.2 %	2.6 %	1.8 %	2.5 %	2.3 %	2.5 %

2005 оноос 2014 он хүртэлх Вьетнамын батлан хамгаалах салбарт зарцуулсан төсөв¹¹

10. <http://www.tinmoi.vn/tag/bien-dong>

11. Tradingeconomics.com, Vietnam Military White Papers-ийн мэдээллийг харьцуулж гаргав.

Вьетнамын батлан хамгаалах салбарт зарцуулсан мөнгөний ихэнх хэсгийг шумбагч онгоц, зэвсэг худалдан авч, тэнгисийн цэргийн хүчнийг сургахад зарцуулж байна.¹²

Вьетнам тэнгисийн цэргийн хүчнээ шинэчлэхээр Оросын тэнгисийн зэвсэг, тоног төхөөрөмж худалдан авдаг томоохон харилцагчдын нэг болсон. Вьетнам улс нь 2015 онд Оросын зэвсгийг импортлогч гурван орны нэг болно гэсэн судалгаа байдаг. (Энэтхэг, Венесуэл).

➤ Маргааныг дипломат аргаар шийдвэрлэх

XXI зууны эхэн үе хүртэл Вьетнам улс Парасель, Спратлийн асуудалд БНХАУ-тай “энх тайвныг эрхэмлэсэн” байдлыг хадгалахыг хичээж, “тайван” байдал дээр суурилсан дипломат арга хэмжээ авч ирсэн. Хятад, АСЕАН-ы хооронд 2002 онд “Өмнөд Хятадын тэнгист талуудын ёс зүйтэй байх тухай” тунхаглалд гарын үсэг зурсан. Сүүлийн жилүүдэд Хятадын гаргаж байгаа үйлдлүүд Вьетнам болон АСЕАН-ын бусад орнуудад “энх тайвныг эрхэмлэхээ нэмэгдүүлэх”¹³ бодлогод эргэлзэхэд хүргэсэн. Ялангуяа сүүлийн 3 жилийн хугацаанд Хятад Өмнөд Хятадын тэнгист загасчлах, судалгаа хийхийг хориглож, хурцадмал байдлыг нэмэгдүүлж байна.

БНХАУ-ын Өмнөд Хятадын тэнгис дэх бодлого Вьетнамыг дэлхийн бусад улс орнуудтай хамтын ажиллагаагаа бэхжүүлэхэд хүргэсэн. Вьетнамын дипломат бодлого нь Өмнөд Хятадын тэнгисийн маргаанд Хятадыг тогтоон барих зорилготой.

Өмнөд Хятадын тэнгис дэх энх тайван тогтвортой байдлыг хадгалах, хамтын ажиллагааг хөгжүүлэхэд Хятадтай хийх яриа хэлэлцээрийн суурь болсон “Өмнөд Хятадын тэнгист талуудын ёс зүйн байдлын тухай” тунхаглалын хэрэгжилтийг чиглүүлэх хэлэлцээр¹⁴, Өмнөд Хятадын тэнгис дэх ёс зүйн хэм хэмжээний хууль тогтоомжийн үндсэн элементүүдийн талаарх хэлэлцээрт (COC)¹⁵ АСЕАН Хятадтай тохиролцоонд хүрэхэд Вьетнам чухал үүрэг гүйцэтгэсэн.

12. <http://www.mod.gov.vn>

13. China's Peaceful Rise. http://en.wikipedia.org/wiki/China's_peaceful_rise

14. Declaration on the Conduct of Parties in the South China Sea 2002.

<http://www.asean.org/asean/external-relations/china/item/declaration-on-the-conduct-of-parties-in-the-south-china-sea>

15. the Code of Conduct for the South China Sea

Өмнөд Хятадын тэнгис нь туйлын эмзэг асуудал гэж АСЕАН мэдэгдсэн¹⁶ ба энэ асуудлыг онцлон авч үздэг.

➤ Олон улсын шүүхэд хандах

Вьетнам бүрэн эрхээ бэхжүүлж, БНХАУ-тай маргаан үүсгээд байгаа Өмнөд Хятадын тэнгисийн асуудлыг шийдвэрлэхийн тулд түүхэн эх сурвалж, баримтуудад тулгуурлан олон улсын эрх зүйг ашиглахаар ажиллаж байна.

Түүхэн баримтаас үзэхэд Вьетнам XVII зууны үеэс Парасель, Спратлийн бүлэг арлуудыг эзэмшиж байсан. Дай Намын нэгдсэн улсын 1838 онд бүрэн хийж дууссан газрын зураг (大南一統全圖)¹⁷-т Спратлийн бүлэг арлууд нь Вьетнамын нутаг дэвсгэр гэж тэмдэглэгдсэн байдаг. Вьетнам арлуудад газар зүй, нөөцийн олон судалгаа хийгдсэн. Эдгээр судалгааны үр дүн XVII зуунаас хойш хэвлэгдсэн вьетнамын утга зохиол, түүхийн сурвалж бичигт тэмдэглэгдсэн байдаг.

Дэлхийн II дайны эцсээр боловсруулсан Каирын тунхаглалд Холбоотнууд Японоос авч Хятадад буцааж өгөх нутаг дэвсгэрийн жагсаалтыг гаргасан ба уг жагсаалтад Спратлийн бүлэг арлууд багтаагүй байсан.

Вьетнам, Хятад, Өрнөдийн баримт бичгүүдэд Парасель, Спратлийн бүлэг арлууд, Өмнөд Хятадын тэнгис дэх бүрэн эрх байдлын талаар тэмдэглэгдсэн байдаг.

А. Вьетнамын баримт бичиг:

- 1686 он, газрын зураг,
- 1776 он, “Аннамдын зам” ном,
- 1821 он, Фан Хью Чу-ын бүтээл,
- 1833 он, Хоанг Вьет-ын бүтээл,
- 1851 он, Кхам Динь Дай Нам, Хой Диен Су Лэ, 207-р боть г.м

16. <http://www.asean.org>

17. http://vi.wikipedia.org/wiki/%C4%90%E1%BA%A1i_Nam_nh%E1%BA%A5t_th%E1%BB%91ng_to%C3%A0n_%C4%91%E1%BB%93

В. Хятадын баримт бичиг:

- 1696 онд海外紀事 (Хилийн чанад дахь өдрийн тэмдэглэл) Ху Shilian,
- 1909 оноос өмнө зурсан Хятадын эртний газрын зурагт Xisha (Парасель), Nansha (Спратли) Хятадын эзэмшилд байгаагүй гэдгийг харуулдаг,
- 1909 өмнөх Эртний Хятадын газрын зургуудад Xisha болон Nansha арлын тухай тэмдэглэсэн нэг ч зураг байхгүй. Эдгээр бүх газрын зургууд дээр Хятадын өмнөд хилийн хамгийн урд хэсэг бол Хайнань гэж тодорхойлогдсон байдаг.

С. Өрнөдийн баримт бичиг:

- Marie de Bourbon as Amphitrite, 1701 он, Параселийн арлууд нь Аннам улсын нутаг дэвсгэр,
- “Le Memoire sur la Cochinchine” Jean Baptiste Chaigneau (1769-1825),
- “Univers, histoire et description de tous les peuples, de leurs religions, mœurs et coutumes”, 1833 он, 1816 он, Параселийн бүлэг арлууд Заа Лонг хааны эзэмшлийн нутаг,
- LTaberd Map of great empire of An Nam (An Nam-ийн их эзэнт гүрний газрын зураг),
- The Journal of the Asiatic Society of Bengal, Vol VI for the post of Bishop King Gia Long,
- “ The Journal of the Geographycal Society of London”, 1849 он тус тус Парасель, Спратлийн бүлэг арлууд нь Вьетнамын нутаг дэвсгэр гэдгийг баталсан байдаг.

Вьетнам нь Далайн эрх зүйн тухай 1982 оны НҮБ-ын конвенцид нэгдсэн. Уг конвенц нь эргийн улс орнууд эх газрын хормойг байгалийн нөөц баялгийг судлахад ашиглахыг зөвшөөрдөг. Газар зүйн хувьд, Параселийн бүлэг арлуудын Жи дон арал нь Вьетнамын Куанг Нгай мужаас 135 милийн зайд, Паттле арал нь Вьетнамын эх газраас

дөнгөж 160 милийн зайд оршдог. Тиймээс Параселийн бүлэг арлууд нь Вьетнамын эх газрын хормойд багтах ба дээр дурьдсан конвенцийн дагуу зохицуулагдана. Геологийн хувьд, шинжлэх ухааны судалгаанууд Параселийн бүлэг арлууд нь Вьетнамын нэг хэсэг гэдгийг харуулдаг. Газрын зураглалын үүднээс, шинжлэх ухааны ихэнх судалгаанууд Параселийн бүлэг арлууд Вьетнамын усан доорх газар нутаг гэдгийг гэрчилдэг. Геологи, газрын гадаргын хувьд, Спратлийн бүлэг арлууд нь тэнгис дэх Вьетнамын эх газрын үргэлжлэл юм. Спратлийн бүлэг аралд харьяалагддаг Вангуард эрэг, Сторм арал нь Вьетнамын эх газраас 150-200 милийн зайд байрладаг.¹⁸

Хятадын бодлого, байр суурь

Өнгөрсөн зууны 70-аад оноос БНХАУ-ын эдийн засаг сэргэж аж үйлдвэр хөгжин эрчим хүчний хэрэгцээ улам их болохын хамт далайн эрэг хавийн байгалийн баялгийг олборлох ажилд анхаарлаа хандуулж эхэлсэн. Энэ нь угаас түүхэн маргаан дагуулдаг Өмнөд Хятадын тэнгисийн хилийн заагийг дахин авч үзэх сонирхлыг өдөөсөн байна. Ер нь геостратегийн чухал байршилтай энэ тэнгис бол хэзээнээс их гүрнүүдийн сонирхлын уулзвар гэдэг нь тодорхой.¹⁹

2007 он хүртэл Өмнөд Хятадын тэнгис дэх БНХАУ-ын үйл ажиллагаа, хандлага нь Хятадын улс төрчид ихэвчлэн геополитикийн болон геостратегийн үүднээс Өмнөд Хятадын тэнгисийг үздэг байсан гэдгийг харуулж байна. Өмнөд Хятадын тэнгис нь Зүүн өмнөд Азид гарах гарц бөгөөд цаашид далай тэнгисийн эрчим хүчтэй болох боломжийг Хятадад бүрдүүлж өгнө.

Өөрчлөлт шинэчлэлтийн бодлого явуулсанаас хойш 40 жилийн дараа БНХАУ эдийн засаг, цэргийн салбарт ихээхэн үсрэлт хийж чадсан. 2012 онд ДНБ 8 их наяд ам.доллар²⁰ буюу Зүүн өмнөд Азийн орнуудын ДНБ-ээс өндөр, цэргийн зардлаараа АНУ-ын дараа 2-т ордог ба 2012 онд 166 тэрбум ам.доллар²¹ байсан.

18. Article 76, Definition of the continental shelf, United Nations Convention on the Law of the Sea http://www.un.org/depts/los/convention_agreements/texts/unclos/unclos_e.pdf

19. С.Дашцэвэл, Өмнөд Хятадын тэнгист юу болж байна вэ?, 2014

20. <http://data.worldbank.org/country/china>

21. Military Expenditure Database <http://milexdata.sipri.org/files>

Хятад нь Өмнөд Хятадын тэнгис дэх хурцадмал байдлын түвшинг тодорхойлогч гэж хэлж болох талтай. Зүүн өмнөд Азийн орнуудтай улс төр, эдийн засгийн харилцаа сайтай, аюулгүй байдлын асуудалд зөөлөн хүчний бодлого баримталдаг байснаа 2007 оноос энэхүү бодлогоосоо илт ухрах болсон.²²

2007 оны дунд үеэс Өмнөд Хятадын тэнгисийн маргаан илүү хурцадмал болсон. 2010 онд болсон АРФ-ын 17-р уулзалтаар Өмнөд Хятадын тэнгисийн маргааныг авч хэлэлцэн, оролцогч 28 орны 11 нь өөрсдийн байр сууриа илэрхийлсэн байдаг. АРФ-ын уулзалтаар Өмнөд Хятадын тэнгисийн маргааныг авч хэлэлцсэн нь энэхүү форумын хувьд түүхэн үйл явдал болсон.²³

Хятад АСЕАН-тай Өмнөд Хятадын тэнгисийн бүсийн дүрмийг баримтлах талаар тохиролцсон хэдий ч уг амлалтаа биелүүлэх хугацааг ямар нэгэн аргаар сунгахыг байнга хичээсээр ирсэн гэж үзэж болох юм. НҮБ-ын Далайн эрх зүйн конвенцид гарын үсэг зурсан ч үүнийхээ хажуугаар ямагт “энэ конвенц үндэстний газар нутгийн бүрэн эрхийн талаарх маргааныг шийдвэрлэх олон улсын хэлэлцээр биш бөгөөд аливаа маргааныг шийдвэрлэхэд энэ конвенцийг иш татах ёсгүй”²⁴ гэдэг.

Өмнөд Хятадын тэнгисийн маргаан

Вьетнам, Хятадын харилцаанд нөлөөлөх нь

Хятад маргаантай зарим арлуудыг газрын зураг, ном, сэтгүүлд өөрийн эзэмшил хэмээн бичиж тэмдэглэх болсон нь ард түмний оюун санааг аажмаар залгих буюу “нэг удаа худал хэлэхэд хүмүүс итгэхгүй, иймээс хүмүүсийг энэ худал үгэнд үнэн хэмээн итгэтэл нь мянган удаа худал хэл” гэсэн зарчмын дагуу ажиллаж байна гэж Вьетнамын зарим судлаачид үздэг байна.²⁵

Вьетнамчууд Хятадын ард түмнийг болон тэдний улс төрийн чиг хандлагын дэмжиж, зарим цагт үндэсний хувьсгалынхаа төлөө

22. Joshua Kurlantzick, “Avoiding a Tempest in the South China Sea”, Expert brief, Council on Foreign Relations, September 2, 2010, <http://www.cfr.org/china/avoiding-tempest-south-china-sea>

23. <http://www.asean.org>

24. Brice M. Claget, The opposition claims of Vietnam and China in the underground beach area from the dragon and in the South China Sea, National Political Publishing House, Hanoi, 1996

25. Quyển trkn hai quan đảo Hoang Sa va Trường Sa, Nha xuất bản chính trị quốc gia, 2001

тэдэнтэй эвсэн тулалдаж ирсэн. Вьетнамын ард түмэн Хятадын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, газар нутагт халддаггүй, дотоод асуудалд нь хөндлөнгөөс оролцдоггүй. Үүссэн аливаа асуудлыг ямагт хоёр талын яриа хэлэлцээрийн замаар шийдэхийг хичээдэг.²⁶

Вьетнам, Хятадын хооронд Парасель, Спратлийн арлуудын асуудлаас болж 1979 онд үүссэн дайнд Хятадын ардын чөлөөлөх арми дайн зарлалгүйгээр 600 мянган цэргийн хүчээр Вьетнам улс руу байлдааны ажиллагаа явуулсан бөгөөд Америк-Вьетнамын дайнд хатуужсан коммунист вьетнамын арми ширүүн тулааны эцэст хятадуудыг ухрааж чадсанаар гал зогсоох гэрээ байгуулсан. Энэхүү нэг сарын дайныг түүхчид “Хятад-Вьетнамын дайн” хэмээн тэмдэглэдэг.

Хоёр улсын харилцаа сүүлийн үед ийнхүү хурцдаж байгаа нь тэднийг 1979 оных шиг дахин зэвсэгт мөргөлдөөнд хүрэх вий гэсэн болгоомжлолыг дагуулж эхэлжээ.

Вьетнам-Хятадын харилцаа нь энх тайвнаар зэрэгцэн орших 5 зарчимд тулгуурладаг. Өнөөг хүртэл хоёр тал Өмнөд Хятадын тэнгисийн маргааны асуудлаар харилцан нэгнийхээ байр суурийг сайтар ойлголцох зорилгоор 11 удаагийн яриа хэлэлцээрийг зохион байгуулсан хэдий ч тодорхой үр дүнд хүрээгүй байна.

ДҮГНЭЛТ

Одоогийн байдлаар энэ бүс нутагт санал зөрөлдөөн, маргаан, давхацсан ашиг сонирхол их байна. Бүс нутагт дангаар ноёрхох санаархал байх боломжгүй юм.

Хоёр талын яриа хэлэлцээ нь маргааныг шийдвэрлэх цорын ганц үр дүнтэй арга гэж үзэж байна. Вьетнам, Хятад хоёр маргаантай асуудлуудаа хэр амжилттай шийдэж чадахаас тэдний ирээдүйн харилцаа тодорхойлогдоно. Хоёр талт хамтын ажиллагааг бүх салбарт хөгжүүлж, эдийн засгийн харилцааг өргөжүүлж байгаа нь хоёр орны харилцааг илүү тогтвортой болгох нэг суурь болж байна. Хоёр талт харилцааны урт хугацааны тогтвортой байдлын төлөвт эерэг нөлөө

26. <http://www.mofa.gov.vn>

үзүүлэх нэг хүчин зүйл нь газар нутгийн маргааныг зохицуулахад гаргах ахиц. Хоёр орон харилцаагаа өргөжүүлэхэд хохирол учруулахгүйн тулд Өмнөд Хятадын тэнгис дэх маргааныг зөв замаар шийдвэрлэх ёстой.

Дипломат ажиллагаа нь гол арга зам учраас маргаантай улс орнууд өөрсдийн байр суурь, ашиг сонирхолоо ухамсарлан, хэлэлцэн тохиролцож, дарамт шахалтыг арилгах арга зам олж, цаашид ирээдүйд харилцан ашигтай байх тогтвортой байдал руу анхаарлаа хандуулах хэрэгтэй.

Үүсээд байгаа асуудалд Вьетнамын тал хүлээцтэй хандаж, дипломат арга барилаар шийдвэрлэхийг, харин Хятадын зүгээс дипломат арга барилаар биш, Вьетнам болон бусад улсуудад цэрэг, эдийн засгийн хүчийг ашиглан дарамт үзүүлэх замаар шийдвэрлэхийг оролдож байгаа нь учир дутагдалтай гэж үзэж байна.